



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 24 өдөр

Дугаар

А/29

Амардалай

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Тус сумын Баянбулаг багийн нутаг "Зүүн өвдөг" гэдэг газар өвөлжиж байгаа малчин Х.Энхбаярын үхэрт мал, амьтны халдварт "Галзуу" өвчний шинж тэмдэг илэрч, аймгийн Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээгээр онош нь баталгаажсан тул 2020 оны 02-р сарын 27 ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

Хоёр: Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, хязгаарлалтын дэглэм тогтоосон газрын зураглалыг хавсралт 2-оор тус тус баталсугай.

Гурав: Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд хамрагдах малчдын үхрийн судалгааг гаргаж вакцинжуулах, хүүр, сэг зэмийг устгаж ариутгах, халдваргүйтгэх арга хэмжээг зохих зааврын дагуу хийж гүйцэтгэхийг "Дэлгэрбаяндалай" ХХК-ны малын их эмч /Т.Нарангэрэл/, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга /Д.Наранцэцэг/ нарт даалгасугай.

Дөрөв: Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсийн хүн, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавихыг 1-р багийн Засаг дарга /П.Мөнхзориг/, Цагдаагийн хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ИШ-ЁНДОН

4880100068